



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 6/271

Улаанбаатар хот

Н.Насанбуянд хилийн боомт, орон нутаг дахь албанд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.3.7, 8.4, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2019 оны А/75 дугаар тушаалаар баталсан "Орон нутаг дахь газрын ажиллах журам"-ын 10.11-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хилийн боомт, орон нутаг дахь албанд хяналтын улсын байцаагчаар таваас доошгүй жил ажилласан Баруун бүс дэх газрын хяналтын улсын байцаагч Нямцэвээний Насанбуянд мөнгөн урамшуулал олгосугай.

2.Урамшуулалд шаардагдах 17.307.647 /арван долоон сая гурван зуун долоон мянга зургаан зуун дөчин долоо/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, хангалт, үйлчилгээний газар /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН